



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баацагаан сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БНА-2024/110/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот

2024 оны 02 дугаар сар 20

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын  
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат  
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn  
Ахлах аудитор М.Алтантуяа  
Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Номгон аудит ХХК  
Захирал Г.Саранчимэг  
Утас: 89891034 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com  
Аудитор: О.Мандах  
Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>Асуудлыг онцолсон хэсэг</b> .....	3
<b>Аудитын гол асуудал</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	14
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	14
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	15
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .	15
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	15
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	15
<b>4.5.1 Завсрын аудитын талаар</b> .....	15
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</b> .....	16
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



БААЦАГААН СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Ч.ЭНХТУЯА ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/43  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баацагаан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баацагаан сумын Цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 71802 хөтөлбөрийн 8 арга хэмжээний зардалд улсын төсвөөс 349,060.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 30,945.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд улсын төсвөөс 266,498.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 30,945.0 мянган төгрөгийг зарцуулж мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл тайлант оны эцэст 82,562.3 мянган төгрөг байна.

**Аудитын гол асуудал**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Аудитаар улирлын үр дүнгийн урамшууллын хувь буруу тооцсон, цахим дата хэрэглээний зардлыг журмын дагуу зарцуулаагүй, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гарсан боловч илэрсэн зөрчил нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг алдааны түвшнээс бага байна.

3020179

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Баацагаан сумын цэцэрлэгийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 100 хувьтай тайлагнасныг 94.3 хувьтай дээд шатны байгууллагаас дүгнэсэн байна.

Баацагаан сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

A red rectangular official stamp of the State Audit Agency of Mongolia is positioned in the center. It contains the Mongolian text 'МОНГОЛЫН АУДИТЫН АГЫ' (State Audit Agency of Mongolia) and 'УЛСЫН АУДИТ' (State Audit). A large, stylized handwritten signature in black ink is written over the stamp. A long horizontal line extends from the right side of the signature across the page.

Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	111,056,656.18	123,110,362.23
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	76,950,471.30	82,562,379.72
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	76,950,471.30	82,562,379.72
31210	Төгрөг	76,950,471.30	82,562,379.72
31211	Төрийн сангийн харилцах	76,950,471.30	82,562,379.72
33	АВЛАГА	240,634.44	19,682.07
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	240,634.44	19,682.07
35	БАРАА МАТЕРИАЛ	33,865,550.44	40,528,300.44
35100	Түүхий эд материал	14,942,030.00	14,150,630.00
35110	Тусгай зориулалттай материал	13,835,630.00	13,835,630.00
35130	Эм боох материал	1,106,400.00	315,000.00
35400	Хангамжийн материал	18,923,520.44	26,377,670.44
35410	Бичиг хэргийн материал	1,482,500.00	985,040.00
35420	Аж ахуйн материал	17,441,020.44	25,392,630.44
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	693,387,975.27	689,515,495.08
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	693,387,975.27	689,515,495.08
39200	Биет хөрөнгө	686,373,975.27	682,501,495.08
39201	Барилга, байгууламж, орон сууц	695,951,607.00	695,951,607.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-50,294,768.88	-63,856,421.52
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	36,875,600.00	39,050,500.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-16,673,829.99	-23,581,846.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,093,316.80	46,093,316.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,401,149.66	-31,967,200.56
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,224,230.00	23,212,570.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,224,230.00	-3,224,230.00
39217	Ном	823,200.00	823,200.00
39300	Биет бус хөрөнгө	7,014,000.00	7,014,000.00
39301	Программ хангамж	100,000.00	100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-100,000.00	-100,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,014,000.00	7,014,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	804,444,631.45	812,625,857.31
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	737,752.00	231,853.56
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	737,752.00	231,853.56
41300	Өглөг	737,752.00	231,853.56
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	666,376.00	0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	231,853.56

Баацагаан сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

41360	Бусад өглөг	71,376.00	0
41361	Байгууллагад төлөх өглөг	71,376.00	0
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>803,706,879.45</b>	<b>812,394,003.75</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>803,706,879.45</b>	<b>812,394,003.75</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	109,732,440.58	109,732,440.58
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	109,732,440.58	109,732,440.58
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>64,015,638.43</b>	<b>72,702,762.73</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-726,436,693.00	64,015,638.43
51220	Тайлант үеийн үр дүн	790,452,331.43	8,687,124.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	629,958,800.44	629,958,800.44
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>804,444,631.45</b>	<b>812,625,857.31</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,112,840,188.84</b>	<b>403,509,200.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>743,506,688.84</b>	<b>23,502,700.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	743,506,688.84	23,502,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	35,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	718,322,658.40	21,248,340.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	25,184,030.44	2,219,360.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>369,333,500.00</b>	<b>380,006,500.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>333,356,200.00</b>	<b>349,060,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	333,356,200.00	349,060,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,977,300.00	30,945,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,977,300.00	30,945,800.00
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>322,387,857.41</b>	<b>394,822,075.70</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>322,387,857.41</b>	<b>394,822,075.70</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>318,445,916.21</b>	<b>394,814,825.70</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>192,110,504.30</b>	<b>255,801,677.16</b>
210101	Үндсэн цалин	147,471,234.55	228,991,595.48
210102	Нэмэгдэл	30,545,522.55	24,726,887.98
210104	Урамшуулал	4,128,699.20	2,083,193.70
210105	Гэрээт ажлын хөлс	9,965,048.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,887,626.96	31,600,814.79

**Баацагаан сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210201	Тэтгэврийн даатгал	28,260,989.96	21,729,912.69
210202	Тэтгэмжийн даатгал	1,156,659.00	2,552,629.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	925,328.00	2,042,103.10
210204	Ажилгүйдлийн даатгал	231,331.00	470,345.39
210205	Эрүүл мэндийн даатгал	2,313,319.00	4,805,824.48
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>23,474,656.80</b>	<b>29,827,653.56</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,293,276.80	4,701,645.56
210302	Түлш, халаалт	19,938,380.00	23,926,008.00
210303	Цэвэр, бохир ус	1,243,000.00	1,200,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>0</b>	<b>7,053,540.00</b>
210401	Бичиг хэрэг	0	1,580,960.00
210402	Тээвэр, шатахуун	0	583,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0	319,530.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0	4,569,200.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>36,320,625.00</b>	<b>36,283,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0	791,400.00
210502	Хоол, хүнс	36,320,625.00	35,491,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>263,500.00</b>	<b>1,042,750.00</b>
210604	Урсгал засвар	263,500.00	1,042,750.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>715,000.00</b>	<b>795,600.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	715,000.00	795,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>32,674,003.15</b>	<b>32,409,790.19</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,173,020.00	4,969,970.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	255,300.00	1,404,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,245,683.15	26,035,720.19
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,941,941.20</b>	<b>7,250.00</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,941,941.20</b>	<b>7,250.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,941,941.20	7,250.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>790,452,331.43</b>	<b>8,687,124.30</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>790,452,331.43</b>	<b>8,687,124.30</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	369,333,500.00	380,041,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0	35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0	35,000.00

Баацагаан сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	35,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>369,333,500.00</b>	<b>380,006,500.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	333,356,200.00	349,060,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	333,356,200.00	349,060,700.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>35,977,300.00</b>	<b>30,945,800.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,977,300.00	30,945,800.00
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>292,072,028.70</b>	<b>373,514,691.58</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>292,072,028.70</b>	<b>373,514,691.58</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>288,130,087.50</b>	<b>373,507,441.58</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	188,583,075.00	256,316,119.72
210101	Үндсэн цалин	143,943,805.25	187,338,992.25
210102	Нэмэгдэл	30,545,522.55	58,370,183.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	5,440,000.00
210104	Урамшуулал	4,128,699.20	5,166,943.70
210105	Гэрээт ажлын хөлс	9,965,048.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,165,065.70	31,620,496.86
210201	Тэтгэврийн даатгал	19,128,200.30	21,749,595.61
210202	Тэтгэмжийн даатгал	1,980,746.78	2,552,628.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,584,497.11	2,042,103.23
210204	Ажилгүйдлийн даатгал	394,164.95	470,345.32
210205	Эрүүл мэндийн даатгал	4,077,456.56	4,805,823.77
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>23,726,656.80</b>	<b>29,895,800.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,293,276.80	4,469,792.00
210302	Түлш, халаалт	19,938,380.00	23,926,008.00
210303	Цэвэр, бохир ус	1,495,000.00	1,500,000.00
2105	<b>Норматив зардал</b>	<b>36,337,950.00</b>	<b>35,474,275.00</b>
210502	Хоол, хүнс	36,337,950.00	35,474,275.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	498,000.00	1,042,750.00
210604	Урсгал засвар	498,000.00	1,042,750.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>814,000.00</b>	<b>795,600.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	814,000.00	795,600.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>11,005,340.00</b>	<b>18,362,400.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,389,940.00	15,973,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,615,400.00	2,388,700.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,941,941.20</b>	<b>7,250.00</b>
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олг ох татаас, санхүүжилт	3,941,941.20	7,250.00

Баацагаан сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,941,941.20	7,250.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	77,261,471.30	6,526,808.42
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	311,000.00	914,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	311,000.00	914,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	311,000.00	914,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	311,000.00	914,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-311,000.00	-914,900.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	76,950,471.30	5,611,908.42
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	76,950,471.30
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	76,950,471.30	82,562,379.72

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	109,732,440.58	629,958,800.44	64,015,638.43	803,706,879.45
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	109,732,440.58	629,958,800.44	64,015,638.43	803,706,879.45
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	109,732,440.58	629,958,800.44	64,015,638.43	803,706,879.45
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	8,687,124.30	8,687,124.30
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	109,732,440.58	629,958,800.44	72,702,762.73	812,394,003.75

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		76,950,471.30	76,950,471.30	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	456,991,900.00	342,034,291.58	114,957,608.42	74.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	456,991,900.00	342,034,291.58	114,957,608.42	74.8

**Баацагаан сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>456,991,900.00</b>	<b>372,980,091.58</b>	<b>-84,011,808.42</b>	<b>81.6</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>312,114,700.00</b>	<b>256,316,119.72</b>	<b>-55,798,580.28</b>	<b>82.1</b>
210101	Үндсэн цалин	218,209,100.00	187,338,992.25	-30,870,107.75	85.9
210102	Нэмэгдэл	88,726,700.00	58,370,183.77	-30,356,516.23	65.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	5,440,000.00	5,440,000.00	
210104	Урамшуулал	5,178,900.00	5,166,943.70	-11,956.30	99.8
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>39,178,100.00</b>	<b>31,620,496.86</b>	<b>-7,557,603.14</b>	<b>80.7</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,693,200.00	21,749,595.61	-4,943,604.39	81.5
210202	Тэтгэмжийн даатгал	3,121,400.00	2,552,628.93	-568,771.07	81.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,497,200.00	2,042,103.23	-455,096.77	81.8
210204	Ажилгүйдлийн даатгал	624,500.00	470,345.32	-154,154.68	75.3
210205	Эрүүл мэндийн даатгал	6,241,800.00	4,805,823.77	-1,435,976.23	77.0
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>29,895,800.00</b>	<b>29,895,800.00</b>	<b>00.00</b>	<b>100.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,648,100.00	4,469,792.00	-178,308.00	96.2
210302	Түлш, халаалт	23,683,700.00	23,926,008.00	242,308.00	101.0
210303	Цэвэр, бохир ус	1,564,000.00	1,500,000.00	-64,000.00	95.9
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>54,154,800.00</b>	<b>35,474,275.00</b>	<b>-18,680,525.00</b>	<b>65.5</b>
210502	Хоол, хүнс	54,154,800.00	35,474,275.00	-18,680,525.00	65.5
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,050,000.00</b>	<b>1,042,750.00</b>	<b>-7,250.00</b>	<b>99.3</b>
210604	Урсгал засвар	1,050,000.00	1,042,750.00	-7,250.00	99.3
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>796,300.00</b>	<b>795,600.00</b>	<b>-700.00</b>	<b>99.9</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	796,300.00	795,600.00	-700.00	99.9
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>19,802,200.00</b>	<b>17,827,800.00</b>	<b>-1,974,400.00</b>	<b>90.0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,413,200.00	15,439,100.00	-1,974,100.00	88.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,389,000.00	2,388,700.00	-300.00	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>456,991,900.00</b>	<b>349,095,700.00</b>	<b>107,896,200.00</b>	<b>76.4</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>349,060,700.00</b>	<b>349,060,700.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	349,060,700.00	349,060,700.00	0.00	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>30,945,800.00</b>	<b>30,945,800.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
132001	Орон нутгийн төсвөөс	30,945,800.00	30,945,800.00	0.00	100.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>76,985,400.00</b>	<b>35,000.00</b>	<b>-76,950,400.00</b>	<b>0.0</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	35,000.00	0.00	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	76,950,400.00	00.00	-76,950,400.00	0.0
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>76,950,471.30</b>	<b>76,950,471.30</b>	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>82,562,379.72</b>	<b>82,562,379.72</b>	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>16.00</b>	<b>14.00</b>	<b>-2.00</b>	<b>87.5</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	0.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	05.00	03.00	-2.00	60.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баацагаан сумын Цэцэрлэг нь “Хүүхдийн хүсэл зорилгод нийцэн хамтын оролцоотой суралцахуйг дэмжих, сургалтын таатай орчин, багшийн мэргэжлийн ур чадвар, заах арга зүйгээр хөгжүүлэх үйл ажиллагааг чанартай зохион байгуулахад оршино” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Тус байгууллага нь Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захирлын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/01 дугаар тушаалаар Захиргаа аж ахуй, Сургалтын алба бүтэц зохион байгуулалттай 16 орон тоотой, 105 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг цэцэрлэгийн эрхлэгч Ч.Энхтуяа, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч А.Номингэрэл нар зурж, нярваар Г.Чимгээ нар ажиллажээ.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баацагаан сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд тус бичиг баримт нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баацагаан сумын Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,181.2 мянган төгрөгөөр буюу 1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	76,950.40	82,562.30	5,611.90
Авлага	240.6	19.6	-221.00
Бараа материал	33,865.50	40,528.30	6,662.80
Үндсэн хөрөнгө	790,081.90	812,245.10	22,163.20
Хуримтлагдсан элэгдэл	-96,693.90	-122,729.60	-26,035.70
<b>Нийт хөрөнгө</b>	<b>804,444.60</b>	<b>812,625.80</b>	<b>8,181.20</b>
Өр төлбөр	737.7	231.8	-505.90
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	803,706.80	812,394.00	8,687.20
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>804,444.60</b>	<b>812,625.80</b>	<b>8,181.20</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Баацагаан сумын сургуулийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баацагаан сумын цэцэрлэгийн 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 5,611.9 мянган төгрөгөөр өссөн нь дээд шатны төсөв захирагчаас тайлант хугацааны эцэст нэмэлт санхүүжилт орж ирсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл тайлант оны эцэст 221.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх ажилчидтай холбоотой авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл нь өмнөх оноос 40,528.3 мянган төгрөг болж 6,662.8 мянган төгрөгөөр өссөн нь түрээсийн сурах бичгийг орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл нь 812,245.1 мянган төгрөг болж 22,163.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд нөхөн хангалтын зардлаар 700.0 мянган төгрөгийн хөлдөөгч, 1,650.0 мянган төгрөгөөр хивсэн дроз, 1,294.1 мянган төгрөгөөр хүүхдийн тоглоом, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 700.0 мянган төгрөгийн угаалгын машин, 560.0 мянган төгрөгийн телевизор, ОНХС-ын хөрөнгөөр 19,988.3 мянган төгрөгийн цэцэрлэгийн хашааг тус тус орлогоор авч данс бүртгэлд бүрэн тусгасан байна.



Өглөг дансны дансны үлдэгдэл 231.8 мянган төгрөг болж 505.9 мянган төгрөгөөр буурсан нь ХАОАТ-ын өглөг барагдуулж дууссан ба гэрэл цахилгааны зардалд 231.8 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 400,749.9 мянга, орон нутгийн төсвөөс 30,345.8 төгрөгийг зарцуулахаар тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 100,117.9 мянган төгрөгөөр бууруулж 361,323.6 мянган төгрөгөөр анх батлагдсан ба тодотголоор 455,941.9 мянган төгрөг болгож 94,617.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Энэ нь цалин, хөлс нэмэгдсэнтэй холбоотой сургуулийн суралцагчдын гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож байгаатай холбоотой байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802 хөтөлбөрийн 80226, 81605, 81807, 81816, 81823, 81834, 81835, 81844, арга хэмжээг санхүүжүүлэхээр 455,941.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 349,060.7 мянган төгрөгийг улсын төсвөөс 30,945.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 349,060.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 30,945.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд улсын төсвөөс 266,498.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 30,945.0 мянган төгрөгийг зарцуулж мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл тайлант оны эцэст 82,562.3 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 372,972.8 мянган төгрөг буюу 81.6 хувьтай байгаа нь тусгай зориулалтын шилжүүлгийн зардлыг 82,562.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Код	Хөтөлбөр арга хэмжээний нэр	/мянган төгрөгөөр/			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	29,895.80	29,895.80	-	100.00
2	81605	Эрүүл мэндийг дэмжих	1,614.50	1,614.50	-	100.00
3	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	49,699.80	34,944.63	14,755.18	70.31
4	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,859.90	3,859.05	0.85	99.98
5	81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	1,194.50	1,175.00	19.50	98.37
6	81832	Нүүдлийн бүлэгт хамруулах	22,815.10	12,138.85	10,676.25	53.21
7	81834	Боловсролын стандарт	267,125.50	229,268.86	37,856.64	85.83
8	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	79,701.80	60,447.92	19,253.88	75.84
9	81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	35.00	35.00	-	100.00
Нийт			455,941.90	373,379.59	82,562.31	81.89

Эх сурвалж: 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баацагаан сумын Цэцэрлэг нь тайлант онд хүүхдийн хоолны зардалд 49,699.8 мянга төгрөгийн төсөв тус тус батлагдаж зардал бүрд 1 багц тендерийг худалдан авах ажиллагааны tender.gov.mn цахим системээр дамжуулан нээлттэй тендер зарлан харьцуулалтын аргаар Буянт таван буурал ХХК-тай хүнсний материал нийлүүлэх гэрээ байгуулан гүйцэтгэлээр 34,944.6 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжүүлэх хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээс ерөнхий гэрээ байгуулсан гүйцэтгэгчээс Хүүхдэд ээлтэй сургалтын орчин төсөл хөтөлбөрийн нөхөн хангалтын зардлаас 700.0 мянган төгрөгийн хөлдөөгч, 1,650.0 мянган төгрөгөөр хивсэн дроз, 1,294.1 мянган төгрөгөөр хүүхдийн тоглоом худалдан авч харин бусад хангамж бичиг хэргийн бараа материалыг шууд худалдан авалтын аргаар худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баацагаан сумын Цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Номгон аудит ХХК-ийн ахлах аудитор О. Мандах гүйцэтгэж, хяналтыг Баянхонгор аймаг дахь төрийн ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баацагаан сумын цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитад шаардлагатай баримт материалыг Номгон Аудит ХХК-д 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны нийт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлын 394,803.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,948.0 мянган

төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 2,961.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 318,500.9 мянган төгрөгийн 19 гүйлгээ, зарлагын 226,907.5 мянган төгрөгийн 11 гүйлгээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 12 шийдвэрийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

	Мэдээлэл байршуулах хугацаа	Мэдээллийн		Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Мэдээлээгүй	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй	Зөрүү
		төрөл	тоо						
1	Сар бүр байршуулах	4	48	48	48	-	-	-	-
2	Хагас жилээр байршуулах	4	4	4	4	-	-	-	-
3	Жил бүр байршуулах	11	11	11	8	-	-	3	-
4	тухай бүр байршуулах	8	96	96	96	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>27</b>	<b>159</b>	<b>159</b>	<b>154</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Номгон аудит ХХК-ны аудитор А.Мандах гүйцэтгэж аудитаар 37,042.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 37,042.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж, нийцлийн аудиттай холбоотой Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах 1 албан шаардлагыг байгууллагын удирдлагад хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	-	1	-	100.0
Зөвлөмж	2	37,042.0	2	37,042.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>37,042.0</b>	<b>3</b>	<b>37,042.0</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Баацагаан сумын цэцэрлэгийн 2023.05.24-ны өдрийн 24 дугаар албан бичиг

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тус байгууллагаас 2023.05.24-ий өдөр 24 дугаар албан бичгээр ирүүлсэн, зөвлөмжийг бүрэн биелүүлж ажиллажээ.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,414.5 мянган төгрөгийн зөрчил илэрснийг орон нутгийн дансанд төвлөрүүлэх 1 төлбөрийн акт тогтоов.

#### 5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Багш нарын шүдний эмчилгээнд зориулан 1,414.5 мянган төгрөгийг эрүүл мэндийн зардлаас зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, БШУС, ЭМС-ын хамтарсан 2022.06.29-ний өдрийн А/238,А/340 тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хууль журам зөрчин зарцуулсан хөрөнгийн холбогдох буруутай албан тушаалтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Дээрх актын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.



## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
1	Багш нарын шүдний эмчилгээнд зориулан 1414.5 мянган төгрөгийн эрүүл мэндийн зардлаас зарцуулсан байна.	1	1,414.5	0	1,414.5	0	0	0	0	0	0	0	0	0
	<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>1,414.5</b>	<b>0</b>	<b>1,414.5</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн		0						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	0	0					1	0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

--oOo--





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2024 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 55/14210513/БНА/2024  
1110/НА-СНА-ТНУЗ.

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баацагаан сумын Цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Шигтгээ дент шүдний эмнэлэгтэй гэрээ байгуулан 1,414,500.00 төгрөгийг эрүүл мэндийн зардлаас зарцуулсан байна.

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн А/238, А/340 тоот тушаалын 2.1 дэх “Багш нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгоонд хавсралтад заасан хугацааны дагуу хамруулах” Төсвийн тухай хуулийн 16.5.5 “Төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.6 дахь “Эрх бүхий этгээд тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Шигтгээ дент шүдний эмнэлэгтэй байгуулсан гэрээний дагуу шилжүүлсэн 1,414,500.00 /Нэг сая дөрвөн зуун арван дөрвөн мянга таван зуун/ төгрөгийг төсвийн захирагчаар төлүүлж, төлбөрийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэх


5050108

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ирүүлэхийг Баацагаан сумын Цэцэрлэгийн эрхлэгч Ч.Энхтуяа, нягтлан бодогч А.Номингэрэл нарт хариуцуулав<sup>1</sup>.

**ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>2</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

НОМГОН АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР:  О.МАНДАХ



<sup>1</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>2</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно